

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.7.1. Ус хангамж, ашиглалт	9
1.7.2. Уурхайн ус таталт	10
1.7.3. Дулаан хангамж.....	11
1.7.4. Цахилгаан хангамж	11
1.7.5. Хог хаягдал.....	12
2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	13
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	20
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
4.1. Байгаль орчны менежментийн арга хэмжээ ба үүрэг	23
4.2. Байгаль орчны дотоод хяналт шалгалт	24
4.3. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	25
4.4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж.....	26
4.5. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	32
4.6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	33
4.7. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	33
4.8. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	33
4.9. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	33
4.10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	34
БҮЛЭГ II. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	36

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ерөнхий мэдээлэл.....	3
Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим	5
Хүснэгт 3. Брикетийн үйлдвэрийн ажиллах горим	8
Хүснэгт 4. Зам талбайн усалгаанд зарцуулах усны хэрэглээ.....	9
Хүснэгт 5. Алтанширээ ордын гидрогеологийн үзүүлэлт	10
Хүснэгт 6. Уурхайд орж ирэх гүний усны тооцоо.....	10
Хүснэгт 7. Уурхайд орж ирэх гадаргын усны тооцоо	11
Хүснэгт 8. ЦНСк 60/140 төрлийн шахуургын техникийн үзүүлэлт.....	11
Хүснэгт 9. Гидрогеологийн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон хүснэгт.....	16
Хүснэгт 10. Хөрсний хими шинж чанар.	17
Хүснэгт 11. Хөрсний физик шинж чанар.....	17
Хүснэгт 12. Хөрсөн дэх онцгой хортой хүнд металлуудын агууламж.	17
Хүснэгт 13. Хөрсөн дэх хортой био-идэвхт хүнд металлуудын агууламж.	17
Хүснэгт 14. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим	21
Хүснэгт 15. Төслийн байршилтай холбоотой болзошгүй нөлөөлөл	22
Хүснэгт 16. Барилга угсралтын үеийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	26
Хүснэгт 17. Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	27
Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын зардал	31
Хүснэгт 19. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	32
Хүснэгт 20. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажил.....	32
Хүснэгт 21. Төслийн явцад хэрэгжүүлэх түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	33
Хүснэгт 22. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	33
Хүснэгт 23. Хог хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	34
Хүснэгт 24. Байгаль орчныг хамгаалах зардлын нэгдсэн хүснэгт	35
Хүснэгт 25. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал.....	37
Хүснэгт 26. БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид оролцогч талуудад тайлагнах хуваарь	38

ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил.....	4
Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал.....	4
Зураг 3. Гадаад тээвэрлэлтийн маршрут.....	7
Зураг 4. Нүүрсийг холбогчгүй брикетлэх технологийн схем.....	8
Зураг 5. Алтанширээ сумаас уурхай руу татах 35 кVт-ын ЦДАШ.....	12


1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч:	“Өгөөмөр алт” ХХК		
Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн дугаар:	9011066058		
Төсөл хэрэгжүүлэгчийн регистрийн дугаар:	2893819		
Тусгай зөвшөөрлийн дугаар:	MV-021184		
Төслийн нэр:	“Хүрэн нүүрсний ордыг ил аргаар олборлон брикетлэх” төсөл		
Төслийн зорилго:	Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайлалтын үйл ажиллагаа явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.		
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 7-р хороо, 4-р хороолол, 29-318 тоот		
Төслийн талбайн байршил:	Дорноговь аймаг, Алтанширээ сум, Алтанширээ хэмээх газар		
	№	Уртраг	Өргөрөг
	1	110° 32' 42.00" E	45° 30 ' 00.00" N
	2	110° 32' 42.00" E	45° 28 ' 30.00" N
	3	110° 31' 06.67" E	45° 28 ' 30.00" N
	4	110° 31' 06.67" E	45° 28 ' 56.29" N
	5	110° 30' 01.94" E	45° 28 ' 56.29" N
	6	110° 30' 01.93" E	45° 31 ' 04.00" N
	7	110° 31' 20.00" E	45° 31 ' 04.00" N
	8	110° 31' 20.00" E	45° 31 ' 57.00" N
	9	110° 34' 40.00" E	45° 31 ' 57.00" N
	10	110° 30' 40.00" E	45° 30 ' 00.00" N





Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил



Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал

1.2. Төслийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл

MV-021184 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг АМГТГ-ын, Кадастрын хэлтийн даргын 2018 оны 09-р сарын 27-ны өдрийн 661 тоот шийдвэрээр “Өгөөмөр-Алт” ХХК-д олгосон байдаг. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь нийт 2752.33 га талбайг хамарна.

1.3. Төслийн хүчин чадал

Төлөвлөж буй ил уурхайн хүрэн дэх нийт хуулах хөрсний хэмжээ нь эхний 5 жилдээ 24 314.0 мян.м³, олборлох нүүрсний хэмжээ жилд 1.5 сая.тн байхаар тооцоо гарсан. Уурхай нь жилд 347 хоног ажиллах бөгөөд нийт хүчин чадлынхаа хэмжээнд 373 ажилчидтай байна. Брикетлэх үйлдвэрийн хувьд жилд 1 сая.тн нүүрс боловсруулах хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулахаар тооцсон байна.

1.4. Уурхайн ажлын горим

Уурхайн үйл ажиллагаа нь жилийн турш тасралтгүй 347 хоног ажиллана. Үлдсэн 18 хоног нь баяр ёслол болон төлөвлөгөөт бус сул зогсолт байхаар тооцов. Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цагаар ажиллана. Ил уурхайн ажиллах ээлжийн зохион байгуулалтыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

Үзүүлэлт	Нэгж	Утга
Уурхайн жилд ажиллах хоног		
Календарийн хоногийн тоо	хоног	365
Баяр ёслол, бүх нийтийн амралтын хоног	хоног/жил	15
Цаг агаарын саатал, сул зогсолт	хоног/жил	3
Жилд ажиллах хоног	хоног/жил	347
Жилд ажиллах цаг	цаг/жил	8328
Ээлжийн зохион байгуулалт		
Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж/хон	2
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг/ээлж	12
Засвар үйлчилгээний цаг		
Төлөвлөгөөт их засвар үйлчилгээ	цаг/жил	811.98
Урсгал засвар үйлчилгээ	цаг/жил	437.22
Нийт засвар үйлчилгээ	цаг/жил	1249.2
Техникийн бэлэн байдал	%	85%
Ээлжийн цаг ашиглалт		
Үзлэгийн хугацаа	мин/ээлж	15
Ээлж солилцох хугацаа	мин/ээлж	10
Хоолны цаг	мин/ээлж	60
Ул цэвэрлэх, тавцан засах, шилжилт хийх хугацаа	мин/ээлж	20
Бүтээлгүй ажиллах нийт хугацаа	цаг/ээлж	1.75
Ээлжинд бүтээлтэй ажиллах цаг	цаг/ээлж	10.25
Ашиглалтын бэлэн байдал	%	85.4%
Хоногт цаг ашиглалт	цаг/хон	20.5
Ээлжинд хөдөлгүүр унтрах хугацаа	цаг/ээлж	1.0
Ээлжинд хөдөлгүүр ажиллах хугацаа	цаг/ээлж	11.0
Хөдөлгүүр ашиглалтын коэффициент	%	91.7%
Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийн жилд ажиллах цаг		
Бүтээмж	%	90%
Хөдөлгүүр ажиллах цаг	цаг/жил	6488.9
Бүтээлтэй ажиллах цаг	цаг/жил	5441.8

1.5. Олборлолтын технологи

Ил уурхайн процесс нь уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолт, овоолго байгуулах болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюул осолгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах, зорилтод бүтээмжийг хангах ёстой. Ил уурхайд дараах процессууд явагдана. Үүнд:

- ✓ Шимт хөрс хуулалт
- ✓ Өрөмдлөг, тэсэлгээ
- ✓ Ухаж ачих
- ✓ Тээвэрлэх
- ✓ Овоолох

Уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүдийг захиалагч компанийн ажлын даалгаварт тусгасны дагуу авч тооцсон.

Шимт хөрс хуулалт

Ашиглалтын явцад уулын ажил явагдахаар төлөвлөгдсөн талбайн өнгөн хөрсийг Монгол улсад дагаж мөрддөг шаардлага стандартын дагуу 0.3 метр зузаантайгаар урьдчилан хуулна. Шимт хөрс хуулах ажилд бульдозер ашиглах бөгөөд бульдозероор хусаж түрэн хуримтлуулан автосамосвал утгуурт ачигчийн хослолоор ачиж тээвэрлэн шимт хөрсний тусгай овоолгод байршуулна.

Хуулж бэлтгэсэн шимт хөрс нь ашиглалтын явцад болон ордыг ашиглаж дууссаны дараах нөхөн сэргээлтийн ажилд ашиглагдах юм. Шимт хөрсний овоолгын өндөр нь 2 м байх бөгөөд хажуугийн тогтворжилтын өнцөг нь 25-33 градус байна. Шимт

хөрсийг уурхайн үндсэн хөрс хуулалтын ажлаас өмнө хуулж овоолсон байна. Шимт хөрс хуулалтын ажилд Shantui SD13 бульдозер ашиглана.

Өрөмдлөг, тэсэлгээний ажил

Өрөмдлөг

Уурхайн өрөмдлөгийн ажилд Atlas Copco-DM45 маркийн 150-229 мм диаметртэй өрмийн машин ашиглана. Уурхайн өрөмдлөгийн цооногийн гүн 11.2 м, 165 мм диаметртэй байна. Техникийн бэлэн байдлын коэффициентийг 85%-р тооцоход уурхайд нийт 1-2 ширхэг өрмийн машин шаардлагатай байна.

Тэсэлгээ

Хөрсийг тэслэхдээ өнгөн хөрс буюу зөөлөн чулуулгийг тэсэлгээгүй шууд ачихаар, харин нүүрс олборлолтын ажилд өвлийн улиралд тэслэх шаардлага гарч болзошгүй тул өвлийн улиралд олборлох нүүрсэнд тэсэлгээтэй байхаар тооцлоо. Хөрс тэсэлгээнд өгөршлийн бүс дахь нийт хөрсийг тэсэлгээгүй байхаар, олборлох нүүрсний 50%-ийг тэсэлгээгүй, 50%-ийг тэсэлгээтэй байхаар тус тус тооцлоо. Тэсэлгээний ажлыг 7 хоногт 1 удаа явуулна.

Нийт хөрсийг гүний усны төвшнөөс дээш орших, доош орших гэж ангилахад, гүний усны төвшнөөс дээш орших хэсэг нь нийт хөрсний 60% байгаа тул нийт тэсрэх бодисын 60% ANFO буюу энгийн тэсрэх бодис, үлдсэн 40%-д эмульсийн тэсрэх бодис ашиглахаар тооцлоо. Тэсрэх бодисын хувийн зарцуулалт хөрсөнд 0.45 кг/м³, нүүрсэнд 0.35 кг/м³ тус тус байна. Тэсэлгээний хэрэгсэлд цооногийн детенатор, гадаргуун детенатор, өдөөгч, гал дамжуулах утас /ОША/ зэргийг ашиглана. Тэсэлгээний ажлын тооцоог хөрс болон нүүрсэнд тус тусад нь тооцсон.

Ухаж ачих процесс

Уурхайн хувьд жилд 1,500 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтайгаар 27 жил ажиллах ба тус хугацаанд 38.7 сая.тн нүүрс олборлож, 98.36 сая.м³ хөрс хуулна.

Ашиглалтын 27 жилийн хугацаанд нийт 130.6 сая.м³ уулын цул ухаж ачих бөгөөд үүнээс 3.41 сая.тн нь исэлдсэн нүүрс, 98.3 сая.м³ хөрс, 37.78 сая.тн нүүрс тус тус байна. Уурхайд нүүрс олборлолтод 2.4 м³ утгуурын багтаамжтай CAT-349D2L маркийн экскаватор 1 ширхэг, хөрс хуулалтад 8.0 м³ утгуурын багтаамжтай Liebherr-984 маркийн экскаватор 1-2 ширхэг ажиллана.

Тээвэрлэх процесс

Сонгосон экскаваторуудтай хослох байдлаар нүүрс олборлолтод 55 тн даацтай XCMG-TFW321 маркийн автосамосвал, хөрс хуулалтанд 85 тн даацтай XCMG-TFW211 маркийн автосамосвалууд тус тус ажиллана.

Жил бүрийн тээврийн зайнаас хамаарч автосамосвалуудын бүтээл харилцан адилгүй байх ба шаардлагатай автосамосвалын тоог жил тус бүрээр тооцон гаргасан. Экскаваторын төрлөөс хамаарч автосамосвалуудын бүтээл харилцан адилгүй тул автосамосвалын тоог гаргахдаа тухайн нөхцөлөөр тооцсон бүтээлээр авсан.

Автосамосвалуудын жил бүрийн ажлын хэмжээнээс хамаарч 55 тн даацтай XCMG-TFW321 маркийн автосамосвал 1-3 ширхэг, 85 тн даацтай XCMG-TFW211 маркийн автосамосвал 1-6 ширхэг тус тус ашиглана.

Овоолох процесс

Ашиглалтын 27 жилийн хугацаанд нийт 98.4 сая.м³ буюу сийрэгжсэн эзлэхүүнээр 113.1 сая.м³ хөрсний гадаад болон дотоод овоолго үүснэ. Авто тээвэртэй гадаад овоолго үүсгэх бөгөөд үлдэц асгацын хэмжээг 30% байхаар тооцсон. Мөн исэлдсэн нүүрсний овоолгыг хөрсний гадаад овоолгын хажууд үүсгэх ба нийт 4.09 мян.тн буюу сийрэгжсэн


эзлэхүүнээр 3.92 мян.м³ исэлдсэн нүүрсний овоолго үүснэ. Овоолгын ажилд Shantui SD23 маркийн бульдозер 1 ширхэг ажиллана. Мөн уурхай ул цэвэрлэгээнд Shantui SD13 маркийн бульдозер 1 ширхэг ажиллана.

Нүүрс ачилт

Уурхайгаас олборлосон нүүрсийг боловсруулах үйлдвэрийн нүүрсний түр овоолго /агуулах/-д хураана. Нүүрс ачилтын ажилд XCMG ZL50 маркийн 3.0 м³ утгуурын багтаамжтай утгуурт ачигч ажиллана.

Гадаад тээвэр

Боловсруулах үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүнийг уурхайгаас 322 км зайд орших Эрээн боомтод хүртэл тээвэрлэн борлуулна. Эрээн боомт хүртэлх гадаад тээврийг автотээвэр болон төмөр замын тээврээр хийж гүйцэтгэнэ. Авто тээвэр нь уурхайгаас газрын тос боловсруулах үйлдвэр хүртэл 40 км хатуу хучилттай замаар хийгдэнэ. Газрын тос боловсруулах үйлдвэр нь Сайншандаас зүүн хойш 20 км зайд байрлах бөгөөд төмөр замаар холбогдсон.



Зураг 3. Гадаад тээвэрлэлтийн маршрут

Газрын тос боловсруулах үйлдвэрээс Эрээн хүртэл 282 км төмөр замаар тээвэрлэхээр тооцлоо. Гадаад тээвэрт NorthBenz маркийн 120 тн-н даацтай автосамосвал 2 ширхэг ажиллана.

1.6. Нүүрсний холбогчгүй брикетийн үйлдвэр

Алтанширээ хүрэн нүүрсний ордын нүүрсний чийглэгийг бууруулж илчлэгийг нэмэгдүүлэн брикетлэж чулуун нүүрсний чанартай ижил түвшинд хүргэж үнэ цэнийг дээшлүүлэх зорилгоор нүүрсийг холбогчгүй брикетлэх үйлдвэр байгуулна.

Нүүрсийг холбогчгүй брикетлэх технологи


Нүүрсийг брикетлэх гэдэг нь нунтаг нүүрсийг термомеханикийн процесст боловсруулж ижил хэмжээ, жин болон ижил хэлбэртэй шахмалыг пресслэж бэлдэх ажиллагаа юм.

Чулуун нүүрс, антрацитын нунтгийг холбогч бодистой 20-80 МПа даралтаар пресслэн шахмал үйлдвэрлэдэг бол метаморфийн түвшин багатай хүрэн нүүрсний нунтгийг холбогчгүйгээр, 100-120 МПа өндөр даралтаар пресслэн шахмал үйлдвэрлэдэг. 45-60% чийглэгтэй залуу хүрэн нүүрсний нийт чийглэгийн агуулга өндөр байдгаас хамаарч илчлэг бага байдаг ба хадгалах, тээвэрлэх явцад хатаж нунтгарах, исэлдэж шатах зэрэг сөрөг үр дагавартай байдаг. Залуу хүрэн нүүрс нь нүүрсний брикетлэгдэх шинж чанарыг тодорхойлох үндсэн үзүүлэлт болох уян харимхай,

деформацлагдах чадвар өндөртэй. Уян харимхай шинж чанар нь хүрэн нүүрсний метаморфийн түвшингээс хамаардаг.

Олон улсын практикт залуу хүрэн нүүрсийг холбогчгүйгээр, дулааны аргаар брикетлэх технологи түгээмэл ашиглагддаг. Анхан шатны булт бутлуурт буталсан нүүрсийг хатаагуурт хатааж бага зэрэг хөргөсний дараа алхан бутлуураар –6 мм хүртэл бутлаад 40-500°C хэмтэй 0-6 мм бүхэллэгтэй нүүрсийг халуунаар нь холбогчгүйгээр пресслэнэ.

Штемпелийн прессээс гарах брикетийн гадаад температур 70-800 °С, брикетийн дотоод температур 50-600 °С байна.



Зураг 4. Нүүрсийг холбогчгүй брикетлэх технологийн схем

Алтан ширээ хүрэн нүүрсний ордын нүүрсний шинж чанар:

- ✓ Нүүрсний нийт чийглэг дунджаар 40%;
- ✓ Үнслэг дунджаар 14-16%;
- ✓ Эхэлж олборлолт хийх мөргөцгийн нүүрсний нөөц ойролцоогоор 10 сая.тн, уг нүүрсний нийт хүхэр <1%, бусад хэсгийн нүүрсний нийт хүхэр 2.0-3.0%;
- ✓ Дэгдэмхий бодисын гарц дунджаар 45% (хуурай, үнсгүй төлөвт тооцсоноор);
- ✓ Ажлын төлөвт орших нүүрсний илчлэг дунджаар 2800 ккал/кг.

Нүүрсний нийт чийглэг 40%, үнслэг 15% байхад илчлэг 2800 ккал/кг байгаа ба хуурай төлөвт орших нүүрсний илчлэг 4500 – 5500 ккал/кг хүртэл нэмэгдэх боломжтой.

Агаарт удаан хадгалах нөхцөлд гадаргуугийн хэсэг нь хатаж хагарал, цуурал үүссэнээс амархан нунтаграна. Агаарт овоолгоор удаан хадгалахад амархан исэлдэж, шаталт үүсэх тул овоолгын өндрийг 1.5-2.0 м-с хэтрүүлж болохгүй. Өөрөө шаталт нь ихэвчлэн 600°C –с эхэлнэ.

Хүрэн нүүрсний холбогчгүй брикетийн үйлдвэрийн ажиллах горим

Орд нь жилд 1.5 сая.тн нүүрс олборлох хүчин чадалтай ажиллах бөгөөд олборлосон хүрэн нүүрсийг холбогчгүй брикетлэн боловсруулна. Холбогчгүй брикетийн үйлдвэр нь 1.0 сая.тн хүрэн нүүрс брикетлэх хүчин чадалтай байна. Брикетийн үйлдвэрийн ажиллах горимыг дараах хүснэгтэд үзүүллээ.

Хүснэгт 3. Брикетийн үйлдвэрийн ажиллах горим

Ажиллах горим	Нэгж	Тоон утга
Жилийн хуанлийн өдрийн тоо	хоног	365

Жилийн хуанлийн сар	сар	12
Жилийн хуанлийн цаг	цаг	8760
Хоногт ажиллах цаг	цаг	24
Цаг ашиглалт	%	85
Жилд ажиллах хоног	хоног	310
Жилд ажиллах цаг	цаг	7,440
Жилийн хүчин чадал	тн	1,000,000
Цагийн хүчин чадал	тн/цаг	135

1.7. Уурхайн дэд бүтэц, түүхий эд

1.7.1. Ус хангамж, ашиглалт

Ахуйн хэрэглээний усан хангамж, ашиглалт

Унд- ахуйн хэрэглээний усыг гүний худгаас хангана. Төслийн хэмжээнд нийт 373 хүн ажиллах бөгөөд хоёр ээлжээр уурхай дээр ажиллах хүний тоо 187 байна. Нэг хүний хоногийн усны хэрэглээг Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын яамны сайдын 2015 оны 07-р сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтаар нэг ажилчны ээлжинд буюу ажлын байранд хэрэглэх халуун болон хүйтэн усны хэрэглээ 20-200 л/хоног байна.

$$187 \text{ хүн} * 80 \text{ л} = 14.96 \text{ м}^3 / \text{хон}$$

$$14.96 \text{ м}^3 / \text{хоног} * 347 \text{ хоног} = 5.2 \text{ мян. м}^3 / \text{жил}$$

$$5.2 \text{ м}^3 / \text{жилд} * 27 \text{ жил} = 140.4 \text{ мян. м}^3$$

Нийтдээ ашиглалтын 27 жилийн хугацаанд унд ахуйн хэрэглээнд 140.4 мян.м³ ус ашиглахаар тооцоо гарч байна.

Зам усалгаа

Ногоон байгууламжийн усалгааг БОНХАЖСайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” А/301-р тушаалын 13-р хавсралт заасны дагуу “Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм”-д 1 м² талбайд 4 л, “Технологийн хэрэглээ буюу зам, талбайн усалгаа”-д 1 м² талбайд 2 л гэсэн нормыг тус тус баримталж ус хэрэглээний тооцоог хийлээ.

Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 4-10 сард буюу дулааны улиралд 90 хоногийн усалгаа явуулна. 11-3-р сард буюу өвлийн улирал замыг грейдерээр хусаж цэвэрлэнэ. Усны машин нь тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршиж, шаардлагатай тохиолдолд замыг хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 4. Зам талбайн усалгаанд зарцуулах усны хэрэглээ

Ашиглалтын жил	Талбай, м ²	Хоногт урлах тоо, ш	Усны зарцуулалт			
			Норм, л/м ²	Хоногт хэрэглэх усны хэмжээ, м ³ /хон	Жилд хэрэглэх усны хэмжээ, м ³	Хоногт шүүрэх шүүрлийн ус м ³ /жил
1-р жил	24,000	1	2	48	4320	1738.3
2-р жил	25,000	1	2	50	4500	1753.6
3-р жил	30,000	1	2	60	5400	1834.6
4-р жил	35,000	1	2	70	6300	1907.5
5-р жил	40,000	1	2	80	7200	1972.3
6-р жил	42,000	1	2	84	7560	1996.6
7-р жил	44,000	1	2	88	7920	2020.9
8-р жил	46,000	1	2	92	8280	2033.1
9-р жил	48,000	1	2	96	8640	2067.1
10-р жил	50,000	1	2	100	9000	2084.7
11-р жил	54,000	1	2	108	9720	2126.2
12-р жил	56,000	1	2	112	10080	2146.5
13-р жил	58,000	1	2	116	10440	2166.7

14-р жил	60,000	1	2	120	10800	2182.9
15-р жил	62,000	1	2	124	11160	2203.2
16-р жил	64,000	1	2	148	13320	2219.4
17-р жил	66,000	1	2	132	11880	2235.6
18-р жил	68,000	1	2	136	12240	2251.8
19-р жил	70,000	1	2	140	12600	2272.0
20-р жил	72,000	1	2	144	12960	2284.6
21-р жил	74,000	1	2	148	13320	2300.4
22-р жил	76,000	1	2	152	13680	2316.6
23-р жил	78,000	1	2	156	14040	2332.8
24-р жил	79,000	1	2	158	14220	2340.9
25-р жил	80,000	1	2	160	14400	2349.0
26-р жил	82,000	1	2	164	14760	2361.1
27-р жил	83,000	1	2	166	14940	2369.2
Нийт				3132	283680	57867.6

1.7.2. Уурхайн ус таталт

Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших Алтанширээ нүүрсний ордод 2007-2017 онуудад хийсэн эрэл үнэлгээ, хайгуулын ажлаар гидрогеологийн иж бүрэн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тус судалгааны ажлын тайлангийн үзүүлэлтүүдийг доорх хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 5. Алтанширээ ордын гидрогеологийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тооцооны утгууд
1	Уст давхаргын зузаан, m	м	21.08
2	Шүүрэлтийн итгэлцүүр, к	м/хоног	0.53
3	Цооногийн ундарга	л/сек	0.2-1.8
4	Ус дамжуулалтын итгэлцүүр, км	м ² /хоног	10.83
5	Түвшин дамжуулалтын итгэлцүүр, ау	м ² /хоног	1.5*10 ⁴
6	Нөлөөллийн радиус, R	м	130.0
7	Газар доорх усны түвшин, Н	м	6.5-32.2
8	Түвшний бууралт	м	5.5-38.6

Ил уурхайд орж ирэх усны тооцоо

Хүснэгт 6. Уурхайд орж ирэх гүний усны тооцоо

Үзүүлэлтүүд	Тэмдэглэгээ болон нэгж	Ашиглалтын жил					
		1-р жил	3-р жил	5-р жил	10-р жил	23-р жил	27-р жил
Шүүрэлтийн	к	0.53	0.53	0.53	0.53	0.53	0.53
Уст үеийн зузаан	m	21.08	21.08	21.08	21.08	21.08	21.08
Нөлөөллийн радиус	R	427.9	743.1	817.1	903.5	1,266.7	1,364
Ил уурхайн талбайн радиус	R ₀	189.9	505.1	579.1	665.5	1,028.7	1,126
Түрэлтийн дундаж хэмжээ	H	12.0	12.0	12.0	12.0	12.0	12.0
Усны түвшин бууруулах хэмжээ	S	35.6	35.6	35.6	35.6	35.6	35.6
Логарифмийн утга	Log	0.353	0.168	0.150	0.133	0.090	0.083
Хоногт орж ирэх ус	Q, м ³ /хон	126.3	265.7	298.0	335.6	493.07	535.54
Цагт орж ирэх ус	Q, м ³ /цаг	5.26	11.07	12.42	13.99	20.54	22.31
Секундэд орж ирэх ус	Q, л/сек	1.46	3.08	3.45	3.88	5.71	6.20
Жилд орж ирэх ус	Q, мян.м ³ /жил	46.1	97.0	108.7	122.5	179.9	195.4

Уурхайн ашиглалтын эхний жилд хоногт 46.1 м³/хоног ус орж ирэх бол уурхай төслийн гүнд хүрэхэд уурхайд хоногт 195.4 м³ ус шүүрэн орж ирэхээр байна.

Уурхайд орж ирэх хур тунадас, болзошгүй үерийн усны тооцоо

Дорноговь аймгийн нутгийн хойд талаар жилдээ 193.8 мм, зүүн өмнөд хэсгээр 128.7 мм, бусад нутгаар 100.9-113.5 мм хур тунадас унана. Манай орны бусад нутгийн нэгэн адил унаж буй хур тунадасны ихэнх хувь нь дулааны улиралд орж, 91.1-179.1 мм буюу 88-92%-ийг эзэлдэг. Хүйтний улиралд маш бага жилийн хур тунадасны 10 орчим

хувь буюу 9.8-14.7 мм нь ордог. Алтанширээ орд нь Дорноговь аймгийн нутгийн хойд талд байрладаг тул хур тунадасны хэмжээг 193.8 мм-ийг сонгон авлаа.

Хүснэгт 7. Уурхайд орж ирэх гадаргын усны тооцоо

Үзүүлэлтүүд	Тэмдэглэгээ болон нэгж	Ашиглалтын жил					
		1-р жил	3-р жил	5-р жил	10-р жил	23-р жил	27-р жил
Уурхайн талбай	F, мян.м ²	136	383	677	1,462	2,115	2,629
Хур тунадасны хэмжээ	h1, м/жил	0.193	0.193	0.193	0.193	0.193	0.193
Урсцын итгэлцүүр	n	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6
Хугацаа	t	24.0	24.0	24.0	24.0	24.0	24.0
Хоногт орж ирэх усны хэмжээ	Q, м ³ /хон	658.9	1,855	3,280	7,083	10,247	12,740
Цагт орж ирэх усны хэмжээ	Q, м ³ /цаг	27.5	77.3	136.7	295.1	427.0	530.9
Хоногт орж ирэх усны хэмжээ	Q, л/сек	7.6	21.5	38.0	82.0	118.6	147.5

Уурхайд орж ирэх усыг зайлуулах, мөргөцгийг хуурайшуулах ажил

Уурхайн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, найдвартай явуулахад ил уурхайд орж ирэх усыг зайлуулах, нүүрсний үе, давхраас, уурхайн мөргөцгийг хуурайшуулах, шүүрүүлэх ажлыг зайлшгүй гүйцэтгэнэ.

Уурхайд орж ирэх усыг уурхай дотор зумф байрлуулж шавхан гаргана. Уурхайд орж ирэх гадаргын болон гүний усны нийт хэмжээ ашиглалтын эхний жилд 32.7 м³/цаг, 3 дахь жилд 88.39 м³/цаг, 5 дахь жилд 149.0 м³/цаг, 10 дахь жилд 309.1 м³/цаг, 23 дахь жилд 447.5 м³/цаг, 27 дахь жилд 553.1 м³/цаг байна. Хур тунадсаар орж ирэх усыг Дренажийн сувгаар уурхайн мөргөцгийн хамгийн нам дор хэсэгт хуримтлуулан ус өргөх шахуургын (насос) тусламжтайгаар ус таталтыг явуулна. Ус шүүрүүлэлтэд ажиллах тоног төхөөрөмжийн хувьд дизель насос ашиглахаар тооцов.

Уурхайд ЦНСк-180/170 төрлийн шахуурга 1 дэх жилд 1 ширхэг, 7 дахь жилээс 2 ширхэг, 15 дахь жилээс 3 ширхэг, 27 дахь жилийн эцэст нийт 4 ширхэг ажиллахаар байна. Шахуургын техникийн үзүүлэлтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 8. ЦНСк 60/140 төрлийн шахуургын техникийн үзүүлэлт

Шахуур-гын төрөл	Хүчин чадал, мЗ/цаг	Бүрэн түрэлт, м	Хөдөлгүү-рийн чадал, кВт/мин	Эргэлтийн давтамж, эрг/мин
ЦНСК	180	170	132	1475

1.7.3. Дулаан хангамж


Төсөл хэрэгжих хугацаа нь дулааны улирал буюу 4,5,6,7,8,9,10-р сарууд байх тул дулааны хэрэглээ гарахгүй ба шаардлагатай тохиолдолд бага оврын зуухыг ашиглана.

1.7.4. Цахилгаан хангамж

Уурхай нь жилд 1.5 сая.тн нүүрс олборлох хүчин чадалтай бөгөөд уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд бүгд дизель хөдөлгүүртэй.

Уурхайд шаардлагатай нийт цахилгаан хэрэглээнд тулгуурлан, цахилгаан хангамжийн систем, дагалдах байгууламжууд иж бүрнээр баригдана.

Алтанширээ сум нь Дорноговь аймгийн Иххэт – Алтанширээ чиглэлийн 35 кВт-ын ЦДАШ-аар төвийн эрчим хүчний системд холбогдсон бөгөөд Алтанширээ сумаас уурхай хүртэл 5 км урттай 35кВт-ын шугам татаж, 35/0.4 кВт-ын хүчдэлтэй, 1000 кВА чадалтай дэд станц, 35кВт-ын хуурай салгах пункт зэргийг барьж байгуулан цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангахаар төсөлд тусгасан байна.



Зураг 5. Алтанширээ сумаас уурхай руу татах 35 кВт-ын ЦДАШ

1.7.5. Хог хаягдал

Засварын газрын хог хаягдал: Техникийн засварын хэрэглээнд ашигласан шатах тослох материалын хаягдал, дизелийн масло болон бусад тос, тосолгоо материал нь хаягдал болон гарна. Энэхүү хаягдлыг тусгай зориулалтын саванд түр хадгалан хуульд заасан хэмжээгээр “Хог хаягдал”-ын тухай хуулийн дагуу аюултай хог хаягдал зайлуулах, устгах, тээвэрлэх эрх бүхий аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан тогтмол хугацаанд зайлуулах хэрэгтэй.

Ахуйн хог хаягдал: Тус нүүрсний ордыг ашиглах уурхайд нийт 329-373 ажилтан ажиллана. Иймээс уг тооцоог тогтмол ажиллах 373 хүнээр тооцоход, хоногт дунджаар 186.5 кг, сард 5.5 тн, жилд 67.1 тн, 27 жилийн хугацаанд 1812.7 тн хатуу хог хаягдал гаргаж байна. Дээрх тооцоог 1 хүн өдөрт дунджаар 0.5 кг хатуу хог хаягдал гаргахаар хийв. Тус компани нь уурхайн тосгон дахь хатуу хог хаягдлаа зориулалтын багтаамж бүхий саванд хуримтлуулан Дорноговь аймгийн Алтанширээ сумын захиргаатай хийсэн гэрээ, зөвлөмжийн дагуу сумын төвийн хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэхээр төлөвлөсөн.

Ахуйн шингэн хог хаягдал: Унд ахуйн үйл ажиллагаанаас шингэн хаягдал гарна. Унд ахуйн үйл ажиллагаанаас ялгарах шингэн хаягдлын хэмжээг тооцохдоо нийт хэрэглээний 80 % гэж үзэв. Шингэн хаягдлын хэмжээ жилд 15.5 мян.м³, нийт 27 жилийн хугацаанд 41.85 мян.м³ ахуйн шингэн хаягдал гарах тооцоотой байна. Уурхайн төслийн төлөвлөгөөнд уг шингэн хаягдлыг бохирын цооногт хуримтлуулахаар төлөвлөжээ.

Химийн бодисын хаягдал: Төслийн үйл ажиллагаанаас химийн хорт болон аюултай бодисын хаягдал үүсэхгүй.

2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Төсөл хэрэгжих талбай орчмын цаг уур, уур амьсгалын онцлог

Дорноговь аймгийн Алтанширээ сум Төв Азийн геоморфологийн их мужийн Дорнод Монголын мужийн Өөшийн говийн дэд мужид хамаардаг, гандуу дулаан зун, хүйтэн өвөлтэй заримдаг цөлийн бүсэд багтана. “Алтанширээ” цаг уурын харуулын мэдээг үндэслэн уур амьсгалын гол үзүүлэлтүүдийг гаргалаа. Уур амьсгалын гол хүчин зүйл болох агаарын температурыг авч үзвэл жилийн дундаж +4.90С, хамгийн дулаан байх 7-р сарын дундаж температур +24.20С, хамгийн хүйтэн 1-р сарын дундаж температур -16.50С байна.

Сайншанд сум орчмын салхины дундаж хурдны жилийн явц

Диаграмм 2-оос харахад өвлийн саруудад тогтвортой хүйтэн агаарын масс ноёлох учир салхины дундаж хурд 2.5-2.8 м/с, харин хавар 3-р сараас эхлэн өсч 4-р сард хамгийн их утгандаа (4.4 м/с) хүрээд, улмаар салхины дундаж хурд буурч 5-р сард 4.2 м/с болно. Зуны улиралд агаар мандлын тогтворшлоос хамаараад салхины хурд цаашид буурах ба хамгийн бага утга 8-р сард 2.0 м/с хэмжээнд хүрнэ. Цаашид салхины дундаж хурд аажим өсч шилжилтийн улирлын 11-р сард 3.0 м/с хүрсэн байна. Ажиглалтын мэдээнээс үзэхэд Дорноговь аймгийн Алтанширээ сумын орчим хүчтэй салхи (15 м/с дээш хурд)-тай өдрийн тоо 10-20-ийн хооронд хэлбэлзэнэ. Салхи зонхилон баруун, баруун хойд ба хойд зүгээс салхилна.

Салхины нөлөөгөөр газрын гадаргуу дагуу хэвтээ чиглэлд элс, шороо хийсэн зөөгдөж алсын барааг бууруулах үзэгдлийг шороон шуурга гэж хэлнэ. Шороон шуурга болох нь салхины хурд, газрын өнгөн гадаргын шинж байдлаас хамаарна. Иймд “Алтанширээ” харуулын мэдээгээр шороон шуурганы давтагдал харьцангуй өндөр гардаг. Мэдээнээс үзвэл шороон шуургатай өдрийн тоо олон жилийн дундажаар 4, 5-р саруудад хамгийн их 9-н удаа ажиглагддаг бол зарим жил эдгээр саруудад 14-17 удаа шороон шуурга ажиглагддаг нь 2 хоногт 1 удаа шороон шуурга болдогийг илэрхийлнэ.

Цаг агаарын бас нэг таагүй үзэгдэл бол цасан шуурга бөгөөд “Алтанширээ” цаг уурын харуулын ажиглалтаар 10-р сараас 4-р сарыг хүртэл 1-2 удаа цасан шуурга ажиглагдана.

Нийт хур тунадасны дийлэнх нь зуны улиралд 13.2-26.9 мм хэмжээтэй орно. Өөрөөр хэлбэл Сайншанд сумын орчим жилд ойролцоогоор 96.9 мм тунадас орох бөгөөд үүнээс 68% нь зөвхөн зуны улиралд, 16% нь намрын улиралд, 14 орчим хувь нь хаврын улиралд, ердөө 2 гаруй хувь нь өвлийн улиралд ордог байна. Хур тунадастай холбоотой өөр нэг үзүүлэлт бол бороотой болон цастай өдрийн тоо юм. Сайншанд сумын орчим харьцангуй эрт 4-р сараас бороо орж эхлэх ба олон жилийн дундажаар бороотой өдрийн тоо 4-өөс 10-р сарыг хүртэл 2-4 байна. Гэхдээ зарим жил бороо, цас оролгүй өнжих тохиолдол ажиглагдана. Тэгвэл цас 10-р сараас 5-р сарыг хүртэл орох ба цастай өдрийн тоо олон жилийн дундажаар 1-3 байна. Жилд ажиглагдах аянгын 36-42% нь 7-р сард, 92% нь 6-8-р саруудад ажиглагдана. Харин 4 ба 5-р сард аянга цахилгаан зарим жил тохиолдох боловч маш ховор. Олон жилийн дундажаар энэ бүс нутагт жилд ойролцоогоор 14 удаа аянга цахилгаан ажиглагдана. Мөн энэ бүс нутагт мөндөртэй өдрийн тоо цөөн 0.6, мөндөртэй өдрийн хамгийн их тоо 5-аас цөөн байдаг.

2.2. Геологийн тогтоц

Давхарга зүй

Доод Цэрдийн Хөхтээг формац (К₁ht)

Хурдасны газрын гадаргууд үзэгдэх байдал янз бүр ч гэсэн хэсэг хэсэг талбайд илэрч байгаагаараа бусад формацын хурдастай адил юм. Уг формацийн хурдас нь талбайн төв болон урд, зүүн хойд хэсгээр тархсан. Гадаргад ил гаршгүй сэвсгэр хурдсаар хучигдсан байдаг. Уг формацийн хурдас нь ногоовтор, ногоовтор саарал, цайвар ногоон зэрэг өнгө зонхилон янз бүрийн ширхэгт элсжин, шавар, жижиг хайргат хөрзөн, хайргажин, шохойжин, аргиллит болон хүрэн нүүрсний үеэс тогтдог ажээ. Агаарын зургийн тайлагдах байдал нь ерөнхийдөө сайн гэж дүгнэсэн байна. Хурдсын өнгө саарал, цайвар саарал, алаг саарал бөгөөд муруй дүрслэмжтэй илэрц сайтай хэсэгт хурдсын унал, сунал сайн ялгагддаг байна.

Дээд дөрөвдөгч-орчин үеийн хурдас (QIII-IV)

Судалгааны талбайн хэмжээнд их тархсан байдаг. Бүх төрлийн дов толгод бэсрэг уулс, тэдгээрийн хоорондох гуу жалга, гол горхи, хуурай сайр, томоохон хөндийг дүүргэсэн, бэл хормойн төрлийн налуу хажууг бүрхсэн байдаг ажээ.

Дөрөвдөгчийн эхэн үед тогтонги урсац явагдаж, чийглэг орчинд хурдас хуримтлагдаж байсан бол Дөрөвдөгчийн сүүлчээр хуурайшилт ихсэж, аллювиал хожуу туугдас үүсгэсэн том хэмхдэст хурдас хуримтлагдсан байдаг байна. Тэрчлэн аллювиал хошуу туугдсын гадарга нь деформацид орж өргөгдөн жижиг түлхэлтэт бүтэц үүсгэсэн онцлог ажиглагддаг байна. Сэвсүүл гаралтай боловч эвдэрч элэгдээгүй, өвс ургамлаар бэхэжсэн, харьцангуй их талбай нь талбайн төв хэсгийн хөндийд байдаг ажээ.

Орчин үеийн хурдас (QIV)

Судалгааны талбайн урд хэсгээр нэлээн их тархсан. Гарал үүслийн байдлаар нь байран, асган, бэл хормойн гэх мэтээр ангилдаг. Шинэ төрмөлийн муу барьцалдсан сэвсгэр хурдас адилхан бутран эвдэрч байран хурдас үүсгэдэг. Тухайн хурдас болон чулуулгийн найрлагаас хамааран элс шавар үүсдэг байна.

Бэл хормойн гаралтай хурдас нэлээд их тархсан боловч дээд дөрөвдөгч-орчин үеийн хурдаснаас бараг ялгардаггүй, харин жижиг хэмжээний гуу жалга мөргөцгийн ирмэгт нэлээд сайн ажиглагддаг байна.

Суурилаг найрлагатай субвулкан бүрдэл (тлпК₁)

Судалгааны талбайд субвулкан бүрдэл нь харьцангуй бага хэмжээнд баруун хойд, хойд хэсэгт тархсан байна. Субвулкан биет нь агаар сансрын зураг дээр хар саарал гэгээлэгтэй, толгодлог гадаргуутай, агуулагчаасаа муу ялгагддаг байна. Энэ биетийг ногоон саарал өнгийн нягт цул тогтоцтой диабаз-порфирит /метадолерит/ бүрдүүлдэг байна. Уг диабаз-порфиритын биет нь хойд ба баруун урд хэсгээрээ хагарлаар хиллэдэг ба баруун хойд хэсэгт сэвсгэр хурдсаар хучигдсан, Туруу пермийн давхаргадсын бялхмал чулуулгийг зүссэн хил заагтай байдаг байна. Хил зааглалын зурваст эвэржин болоржсон чулуулаг тохиолдох буюу биетийн захаас төв рүү талстжилт тод ажиглагддаг байна.

Доод Триас-дээд Юрийн Бор-Өндөр интруз бүрдэл (ξ-γT₃-J_{1b})

Доод Триас-дээд Юрийн Бор-Өндөр интруз бүрдэл нь серийн талбайн Төв Монголын бүсэд Бударын (L-49-XX-88), Хар-Айраг толгойн (L-49-XX-87), Буйлст толгойн (L-49-XIX-86, L-49-XX-87), Чонотын хоймор, Хярын-Овоо (L-50-VII) массивуудын хэмжээнд тархсан байдаг.

Петрографийн найрлагын хувьд ягаавтар саарал, ягаавтар улаан өнгийн, дунд, дунд-том ширхэгт, жигд цул тесктүүртэй, лейкократ ба бага хэмжээгээр биотит агуулсан боржин, болорт сиенит зонхилон бүрдүүлдэг байна. Тэдгээрийн дотор ягаан, ягаавтар саарал, жижиг ширхэгт боржин-порфир, сиенит-порфирын дэл судал, 0.3-0.5 см

диаметртэй 2 см орчим урт, хар саарал, цагаан утаат кварц, кварцын зөв ургалттай, мөн нил ягаан шоо дөрвөлжин хайлуур жоншны талст бүхий олон жижиг пегматит судлууд тохиолддог ажээ.

2.3. Гидрогеологи

Ордын геологи-хайгуулын талбайн нь гидрогеологийн нөхцөлийн хувьд мезо-койнозойн үеийн уулс хоорондын хөндийн газар доорх усны ангилалд багтана. Гадаргуугийн усан сүлжээ болох гол, горхи, булаг, шанд, нуур цөөрөм лицензийн талбайд байхгүй. Харин талбайгаас зүүн хойш 2 км орчимд “Дөшийн” гар худаг байх ба талбайн өмнөд хэсгээр залган “Бор хөөврийн” газар доорх усны томоохон орд орших бөгөөд уг талбайд нэлээд олон гүний худгууд сүүлийн жилүүдэд гаргасан байна. Харин ордын талбайд газар гүний болон аливаа ус цэг байхгүй болно. Ордын геологи-хайгуулын талбайн хэмжээнд давхарга зүй, литологийн, бүтцийн дагуу гидрогеологийн нөхцөлийг дараах ангилалд авч үзэж байна. Үүнд:

- ✓ Дөрөвдөгчийн настай уст давхарга (Q)
- ✓ Дээд цэрдийн настай Баруун гоёотын свитийн хурдас дахь уст давхарга (K₂bg)
- ✓ Дээд цэрдийн Сайншандын свитийн хурдас дахь уст давхарга (K₂ss)
- ✓ Доод цэрдийн Зүүнбаянгийн свитийн хурдас дахь уст давхарга (K₂dz)

Харин талбайгаас хойш дээрх уст давхаргуудтай залган боржингийн массивийн ан цавын устай комплекс (PR-PZ) байдаг байна. Энэ нь дээрх уст давхаргуудын алсын тэжээгдлийн муж байх боломжтой гэж үзжээ.

Талбайн гидрогеологийн судалгаа

Ордын гидрогеологийн судалгааг 1985-1988 болон 2015-2016 онуудад явуулсан Борхөөврийн говийн газар доорх усны ордод явуулсан гидрогеологийн судалгааны цооногууд болон 2017 онд явуулсан Алтанширээ нүүрсний ордын гидрогеологийн судалгааны цооногуудад 2017 оны 10-р сарын дунд үед усны түвшний хэмжилтийг 1-3 удаагийн давтамжтайгаар хийсэн байна.

Гидрогеологийн судалгаа туршилт-шавхалтын ажлын үр дүнд Алтанширээ геологи-хайгуулын талбайн гидрогеологийн зураг, геологийн зүсэлт, түүний үр дүнгээс харахад газар доорх усны чиглэл нь хойноос урагш буюу Алтанширээ боржингийн массив талаас Бор хөөврийн говийн газар доорх усны орд руу чиглэлтэй байх ба усны түвшний үнэмлэхүй өндөржилт 933 м ДН17-11с цооногоос ДН17-1с цооногийнх нь 875 м байна.

Тухайн талбайд өрөмдсөн 15, 16, 17, 18, болон 5-р цооногуудад туршилт-шавхалтын ажил гүйцэтгэсэн байна. Дээрх цооногуудын усны бууралт нэлээд их, сэргэлтийн хугацаа төдийлөн хурдан биш, төвшний бууралтын 70-80% нь эхний 60-120 минутад сэргэж байжээ.

Газар доорх усны химийн найрлага

Алтан ширээ нүүрсний ордын геологи-хайгуулын талбай нь 1996–1988, 2008–2017, 2015–2016 онууд хийсэн геологи болон гидрогеологийн судалгаануудаас харахад нүүрс агуулагч хурдас нь цэрдийн хурдасны усны химийн найрлага нь сульфат–хлор–гидрокарбонат ангийн холимог найрлагатай натри–кальци–магнийн бүлгийн бөгөөд усны эрдэсжилтийн хэмжээ 0.9 – 1.6 г/л, хатуулга 2.2–1.2 мг -экв/л, рН 7.8–8.6 H₂SiO₃-ийн хэмжээ 2.96 -7.99 мг/л исэлдүүлэх чанар 2.08-15.6 мг/л, хуурай үлдэгдэл 922.03-1639.8 мг/л тооцоогоор 1278-1646 мг/л (практик) тус тус байсан байна. Нүүрс агуулагч цэрдийн хурдсан дахь газар доорх усны зарим үзүүлэлтүүд нь 15, 17, 18, 5 ба 16-р цооногуудын дээжийн усны микрокомпонентүүдийн хэмжээ Fe<0.03–0.18 мг/л, As<0.1

мг/л, Cu<0.01 мг/л, Pb<0.05 мг/л, Sr1.66–1.88 мг/л, Se<0.01 мг/л, Zn<0.01 мг/л, U<1.5*10⁻⁶ мг/л гэж лабораторийн шинжилгээний үр дүнгээр гарсан байна. Усны химийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд эрдэжилт бага зэрэг ихтэй ерөнхий хатуулаг Цооног №15-д 11.7, Цооног №18-д 2.83, Цооног №5 -д 2.2 мг-экв/л байсан ба 1986 онд өрөмдсөн 9-р цооногт 11.7 мг-экв/л буюу <7 мг-экв/л их байгаа нь харьцангуй их хатуулагтай усны ангилалд ордог болохыг тогтоожээ.

Гидрогеологийн үзүүлэлтүүд

Уст давхаргын гидрогеологийн тооцооны үндсэн үзүүлэлтүүдийг туршилт-шавхалт хийсэн Цооног№15, Цооног№5, Цооног№16, Цооног№17, Цооног№18, дугаар цооногууд болон зэрэгцээ талбайд явуулсан газар доорх усны ордын хайгуулын ажлын үр дүнтэй харьцуулан график-аналитикийн буюу туршилт-шавхалтын үеийн усны түвшнийг бууралт, сэргэлт-цаг хугацааны мөрдөлтийн (врем) $C=(2H-S_2)S_2 - (2H-S_1)S_1/(Lgt_2 - Lgt_1)$; $K= 0,366Q:C$. $Lga_y=2Lgr-0,35+l/c$ зэрэг аргаар шүүрэлтийн итгэлцүүр, ус дамжуулах итгэлцүүр, усны түвшин дамжуулалтын итгэлцүүр (a_y) тус тус тооцсон байна. Ордын гидрогеологийн үндсэн үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 9. Гидрогеологийн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон хүснэгт

№	Цооногийн дугаар	Уст үеийн зузаан (м), м.	Тогтонги түвшин, м.	Түвшний бууралт. $S_{op}(м)$	Ундарга $Q(л/с)$	Хувийн ундарга $q(л/с)$	Шүүрэлтийн итгэлцүүр $K(м/хон)$	Ус дамжуулалтын итгэлцүүр $Km(м^2/хон)$	Усны түвшин дамжуулалтын итгэлцүүр $a_y(м^2/хон)$
1	Ц-15	18.0	32.2	5.5	1.8	0.18	1.17	21.06	$1.5 \cdot 10^{-4}$
2	Ц-5	11.0	30.1	20.2	1.0	0.04	0.24	2.64	$1.75 \cdot 10^{-4}$
3	Ц-16	16.9	29.6	16.0	0.5	0.03	0.69	11.66	$1.2 \cdot 10^{-4}$
4	Ц-17	36.0	6.53	38.6	0.4	0.001	0.15	5.4	$1.3 \cdot 10^{-4}$
5	Ц-18	23.5	9.4	98.01	0.2	0.005	0.57	13.39	$1.7 \cdot 10^{-4}$
Ордын дундаж		21.08	-	-	-	-	0.53	10.83	$1.5 \cdot 10^{-4}$

Алтан ширээ геологи-хайгуулын талбайн өмнөх онуудад хийсэн туршилт-шавхалтын үр дүнгээс харахад гидрогеологийн цооногийн усны ундарга 0.2–1.8 л/с , усны тогтсон түвшин 6.5–32.2 м – ийн гүнд , түвшний бууралт 5.5–38.6 м, хувийн ундарга 0.001–0.18 л/с, уст давхаргын дундаж зузаан 21.08 м, шүүрэлтийн итгэлцүүр 0.53 м/хоног байна.

2.4. Хөрсөн бүрхэвч

Талбайн хөрсөн бүрхэвч. Төсөл хэрэгжих талбайд Монгол орны хөрсний ангилалаар (*Хөрсний шинэчилсэн ангилал, 2013*) хээрийн хөрсний бүлэгт багтах нимгэн Цайвархүрэн, ердийн Цайвархүрэн, элсэрхэг Цайвархүрэн болон сайрын хөрс зонхилон тархсан байна. Мөн хужир мараа, хагас бэхжсэн элс багахан талбайг эзэлнэ. Нимгэн Цайвархүрэн хөрс нь толгодорхог газрын гадаргын налуужилт ихтэй хажуу энгэр хэсгээр, ердийн ба элсэрхэг Цайвархүрэн хөрс нь толгод хоорондын гадаргын налуужилт багатай тэгшивтэр газруудад тус тус тархсан байна. Хээрийн судалгаагаар өнгөн хөрсний дээж авсан цэгүүд нь ердийн Цайвархүрэн болон сайрын хөрстэй байсан.

Хөрсний хими-физик шинж чанар.

Дээж авсан цэгүүд дэх өнгөн үе давхаргын (0-15см) урвалын орчин (pH) 8.50-9.20 буюу хүчтэй шүлтлэг шинжтэй, үржил шимийн буюу ялзмагийн түвшин Сайрын

хөрсний өнгөн давхаргад 0.62% буюу маш бага, ердийн Цайвархүрэн хөрсний өнгөн давхаргад 1.19% буюу бага агууламжтай, карбонатын давсжилт байхгүй, хялбар уусах давсжилт (ЕС) 0.10-0.22 dS/m буюу маш бага давсжилттай, ургамалд хялбар ашиглагдах хөдөлгөөнт фосфор 0.25-0.97 мг/100г буюу муу хангамжтай, калийн хангамж 11.5-15.8 мг/100г буюу сайн хангамжтай байна. Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүнд том ширхэгтэй элсэн фракци (56-68%) зонхилсон буюу элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна. Хөрсний эзэлхүүн жин нь өнгөн үе давхаргадаа 1.42-1.44г/см³, доод үе давхаргадаа арай бага буюу 1.35-1.38г/см³ байна. Дээрх үр дүнгүүдээс харахад хөрсний ерөнхий үржил шимийн түвшин багатай, механик үйлчлэлд тэсвэр муутай байна.

Хүснэгт 10. Хөрсний хими шинж чанар.

Дээжний дугаар	Гүн, см	pH _{N2O} (1:2.5)	CaCO ₃ %	Ялзмаг %	ЕС _{2.5} dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
						P ₂ O ₅	K ₂ O
M3-01	0-10	8.65	0.73	0.684	0.120	0.52	12.4
	10-30	9.24	0.97	0.452	0.227	0.25	11.5

Хүснэгт 11. Хөрсний физик шинж чанар.

Дээжний дугаар	Гүн, см	Эзэлхүүн жин, г/см ³	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)			Ширхэгийн бүрэлдэхүүний нэр
			Элс	Тоос	Шавар	
M3-01	0-10	1.42	67.3	16.1	16.6	Элсэнцэр
	10-30	1.38	65.1	18.3	16.6	Элсэнцэр
M3-02	0-15	1.35	56.3	24.1	19.6	Элсэнцэр
	15-40	1.44	68.7	14.6	16.6	Элсэнцэр

Хөрсөн бүрхэвчийн эвдрэл, бохирдлын өнөөгийн төлөв байдал

Хөрсний эвдрэл, доройтол. Одоогийн байдлаар судалгааны талбай нь уурхайн олборлолтын ул мөр байхгүй хайгуулын ажлын үед ашиглагдсан өрмийн нүхийг булж тэгшилсэн, автомашины зам эдгэрсэн байдалтай байна.

Хүнд металлын өнөөгийн түвшин. Судалгааны талбайд одоогоор ямар нэг хортой хүнд металлын агуулга бүхий бодис ашигладаггүй учраас хөрсний хүнд металлын агууламж нь хэвийн түвшинд байна. Дээжинд шинжилгээ хийж үзэхэд кадми, хром, мөнгөн ус, хартугалга гэсэн онцгой хортой хүнд металлууд стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй, кобальт, зэс, никель, стронци, ванади, цайр гэсэн хортой био-идэвхит хүнд металлуудын агууламж нь мөн Монгол улсын стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу ямар нэгэн бохирдолгүй байна.

Хүснэгт 12. Хөрсөн дэх онцгой хортой хүнд металлуудын агууламж.

Дээжний дугаар	Металлын агууламж, мг/кг				
	As	Cd	Cr	Mo	Pb
M3-01 (0-10см)	5.0	<1.0	44	<1	18
Хүлцэх агууламж, мг/кг	6	3	150	5	100

Хүснэгт 13. Хөрсөн дэх хортой био-идэвхит хүнд металлуудын агууламж.

Дээжний дугаар	Металлын агууламж, мг/кг					
	Co	Cu	Ni	Sr	V	Zn
M3-01 (0-10см)	16	18.5	18	214	103	89
Хүлцэх агууламж, мг/кг	50	100	150	800	150	300

2.5. Ургамлын аймаг

Бэлчээрийн ургамалжлын бичиглэл: Дорноговь аймагийн Алтанширээ суманд байрлах “Өгөөмөр алт” ХХК-ийн эзэмшлийн талбайд Баглуур-Монгол өвст говийн уул толгод, Бударгана-монгол өвст болон олимог сөөгт толгод - уулын сайрын гаралтай сөөгт бүлгэмдэл, Монгол өвс-шаваг-харганат цөлөрхөг хээр, Дэрс-сухайт, шар бударганат нам хотосын баянбүрд, Шар мод – баглуурт говь цөлийн толгод, Баглуур-

бударганат говийн толгод, Шар бударгана-дэрст, бударгана-хармагт, нам хотосын бүлгэмдэлтэй.

Дээрхи бэлчээрийн 250 м² талбайд 13-22 зүйл, 1м² талбайд 3-8 зүйл бүртгэж, бэлчээрийн ургамалжлын хувьд ургамлын бүрхэц говийн уул толгодоор 15.0-21.4%, хээр хөндий болон нам хотосын нугаар 24.8-37.0%, га –ийн ургац уул толгодор 0.8-1.9, нам хотосын нугаар 2.0-4.4 цн байна.

2.6. Амьтны аймаг

Судалгааны талбай нь Монгол орны амьтны аймгийн мужлалаар Монгол дагуурын хээрийн тойрогт хамаарагдах ба амьтны аймгийн зүйлийн бүрдэл нь тал хээрийн амьтдаас бүрдэнэ. 2020 оны 7-р сарын хээрийн судалгааны хугацаанд хийгдсэн амьтны ажиглалт болон төслийн талбай дахь амьдрах орчны төлөв байдалд үндэслэн амьтдын зүйлийг бүрдлийг тогтоов.

Сээр нуруугүйтэн

Төслийн талбайд зонхилон тохиолдох сээр нуруугүйтэн амьтад нь шавжууд юм. Шавжийн зүйлийн бүрдэл, популяцийн хэмжээ, тархац нь ургамлан бүрхэвч болон гадаргын уснаас их хамаарна.

2020 оны 07 сард гүйцэтгэсэн хээрийн судалгааны хүрээнд хайрсан далавчтаны багаас *dryas scopoli*, *Neptis rivularis*, *Aporia crataegi*, *Colias aurorina*, *Leptidea sinapsis*, шулуун далавчтаны багаас *Derecantha onos*, *Gampsoclies sedakovi*, *Bryodema holdereri*, *Bryodema tuberculatum*, *Calliptamus abbreviates*, зэрэг зүйлүүд, хос далавчтаны багаас Tachinidae овгийн ялаанууд, хатуу далавчтанаас *Epicauta sibirica*, *Poecilus gebleri*, *Mylabris speciosa* зэрэг зүйлүүд түгээмэл тархсан байна.

Монгол улсын Улаан ном (2013)-нд орсон Махаон дэвүүр (*Papilio machaon*), Спорадикус Үхэр хэдгэнэ (*Bombus sporadicus*), Аполлон эрвээхэй (*Parnassius apollo*) зэрэг ховор зүйлийн шавжуудын тархалт төслийн нутаг дэвсгэртэй давхцах хэдий ч эдгээр зүйлүүд ажиглагдаагүй.

Сээр нуруутан

Хоёр нутагтан, мөлхөгчидийн зүйлийн бүрдэл

Судалгааны талбайд мөлхөгч амьтдаас монгол гүрвэл, бамбай хоншоорт могой, рашааны могой тархсан. Харин монгол гүрвэл, бамбай хоншоорт могой зэрэг нь хад чулуутай уулын энгэр эвэр газраар ихэвчлэн тохиолдоно. Рашааны могой, бамбай хоншоорт могойн үндсэн идэш тэжээл нь мэрэгчид, жижиг шувууд, тэдгээрийн ангаахай, дэгдээхэй юм.

Шувууд

Тал хээрийн шувуудын амьдрах орчин төслийн талбайд бий. Төслийн талбайн ойр орчмын баянбүрдээр шувууд зусаж үржих, мөн нүүдлийн үедээ дайран өнгөрдөг. Дулааны улиралд шувуудын зүйлийн бүрдэл нэмэгдэх бол харин хүйтний улиралд цөөвтөр зүйлийн шувуу тохиолдоно.

Хөхтөн амьтад

МАА, зам харилцаа зэргээс шалтгаалан том хөхтөний тархалт хязгаарлагдсан ба судалгаа ажиглалтын хугацаанд аргаль хонь, хулан, саарал чоно зэрэг том хөхтөн амьтад үзэгдээгүй.

Богино хугацааны ажиглалт судалгааны явцад ажиглагдсан хөхтөн амьтад болон амьдрах орчны нөхцөл, хөхтөний үлий нүх, мөр, ялгадас зэрэг мөр шинж тэмдгийг ашиглан төслийн талбайд 9 зүйлийн хөхтөн байгааг тогтоосон. Цаашдын судалгаагаар хөхтөний зүйлийн тоо нэмэгдэх боломжтой.

2.7. Нийгэм- эдийн засгийн байдал

Алтанширээ сум

Алтанширээ сум нь Улаанбаатар хотоос 450 км, аймгийн төвөөс зүүн хойш 90 км-т байрладаг. Цаг уурын эрс тэс уур амьсгалтай, 734,8 м² газар нутагтай, говь хээрийн бүс нутагтай, баруун урд талаараа Сайншанд, Сайхандулаан, баруун талаараа Айраг, хойд талаараа Иххэт, Хэнтий аймгийн Галшар сум, зүүн, зүүн урд талаараа Дэлгэрэх, Өргөн сумдтай хил залган оршино.

Тус сум нь Түшээт хам аймгийн Говь мэргэн вангийн Хондогын хошуу гэж олонд алдаршсан ба Хун дуут Чогдон хун тайж гэдэг уртын дуучнаараа алдартай. Мөн Хондогын 20 босоо бөх, номч мэргэн гэвш Анги Шагдар зэрэг алдартан төрсөн нутаг.

1923 онд Их дулаан уулын хошууны Баян сум, 1925 онд Баялаг Мааньт, 1931 онд Зүрх чандмань мөн Буян гэх мэт нэрлэгдэж байгаад 1934 онд Алтанширээ сум болсон байна. Энэ үед 420 өрх, 1800 гаруй хүн амтай 54000 толгой малтай байжээ.

Тус сумаас БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар Д.Даваасамбуу, Ардын Их Хурлын Депутат Ж.Базар, Л.Ишдорж, Улсын Их Хурлын гишүүн Я.Батсуурь, Б.Дэлгэрсайхан, Ардын уран зохиолч, Төрийн соёрхолт, Соёлын гавьяат зүтгэлтэн Б.Догмид, Соёлын гавьяат зүтгэлтэн Г.Жамьян, Ш.Гүрбазар, А.Шартолгой, Хүний гавьяат эмч Б.Хэнмэдхэв, С.Жанцанхорол, Гавьяат жүжигчин Ж.Ёндонжамц, Б.Цэвэлмаа, БНМАУ-ын аварга малчин Н.Лувсансэнгэ, Д.Наваан-Осор, Ө.Гомбоцэрэн, Ц.Чойжамц, Д.Аюурзана, Я.Лувсаншарав, Ц.Жамбал, Монгол Улсын Алдарт уяач Ө.Гомбоцэрэн, Г.Шоовдор, Улсын анчин Ж.Базар, Ё.Юндэнсамбуу, Г.Очир, Улсын сайн малчин Д.Цэдэвдорж, Б.Бөхбат, Доктор, профессор Ё.Довчин, Б.Даваажав, Ш.Төмөрсүх, Дэд эрдэмтэн А.Загдаа, Спортын мастер М.Чулуун, С.Пүрбиш, Б.Цагаанмаам, Г.Машбат, В.Агиймаа, Б.Баянсан, зураач Ц.Монгол, зохиолч барилгачин Т.Шарбанди нарын олон алдартнууд төрөн гарсан.

Манай сумын нутагт алт, хайлуур жонш, төмрийн хүдэр, ягаан гантиг, зэс, төмрийн хүдэр, шохойн чулуу, өнгөт чулуу, нүүрс, өнгө өнгийн шороо будгийн тогтоц, цэвэр усны нөөц ихтэй, Сүүлийн үед Тариачийн дүүрэгт хийсэн газрын тосны нөөцийн судалгаа эрдэмтдийн анхаарлыг татаж байна.

Үнэг, чоно, хярс, туулай, дорго, мануул, өмхий хүрэн, таварга, ногтруу, бор шувуу, сар, бүргэд, тас, харцага, шаазгай, хэрээ, өвөөлж, ууль, шар шувуу, аргаль, хар сүүлт, цагаан зээр зэрэг ан амьтад амьдарч байна.

Хүрээ хийдийг холбосон гүнжийн их зам, Ширийн чулуу, Сэнжит хад, Цээлийн тогоо, Зэл чулуу, Дэрсэнэ усны цагаан чулуун хөшөө, Могой булаг, Үзүүр улаан жалцай, Баянбуурал, Тогоо хад, Наймаан усны хиргисүүр, Холбоогийн уулны хайлс, булш, хиргисүүр гэх мэт үзэсгэлэнт болон түүх, дурсгалын газруудтай.

2019 оны хүн амын тоо 1360 ба энэ онд 32 хүүхэд шинээр мэндэлж, сумын нийт өрх 454 байна. Мөн 2019 оны сумын мал 134555 толгойгоор тоологдсон. Адуу 8508, тэмээ 554, үхэр 4757, хонь 73009, ямаа 47727. Нийт 55231 төл бойжуулсан ба 1000-аас дээш малтай өрх 26 байна.

Төвийн эрчим хүч, шилэн кабелд холбогдон, үүрэн холбооны бүх сүлжээ нэвтэрсэн. Тус суманд 320 хүүхдийн суудалтай ЕБСургууль, 60 ортой дотуур байр, 10 ортой Эрүүл мэндийн төв, 50 ортой хүүхдийн Цэцэрлэг, 200 суудалтай Соёлын төв ажилладаг мөн 10 гаруй аж ахуй нэгж суманд үйл ажиллагаа явуулж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Өгөөмөр алт” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Алтанширээ хүрэн нүүрсний ордыг ил аргаар олборлон брикетлэх” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй хоёр эх үүсвэрийг авч үзэж байна. Үүнд:

- ✓ Уурхайн олборлолтын процесс
 - Шимт хөрс хуулалт
 - Өрөмдлөг, тэсэлгээ
 - Ухаж ачих
 - Дотоод тээвэр
 - Овоолго үүсгэх
 - Гадаад тээвэр
 - Автомашины яндангаас гарах утаа
- ✓ Брикетлэх үйлвэрийн процесс
 - Нүүрс бэлдэх хэсэг
 - Бутлах, шигших хэсэг
 - Хатааж пресслэх хэсэг
 - Савалгааны хэсэг
 - Үйлдвэрийн халаах зуухны яндангаас гарах утаа зэрэг сөрөг нөлөөллийн эх үүсвэрээр тооцлоо.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны төлөв байдал, дүгнэлт, өмнө хийгдсэн байгаль, нийгэм эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, газар дээр нь ажилласан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн “Магадлан жагсаах буюу хяналтын хуудасна арга” (checklist)-аар тодорхойлсон болно. Үнэлгээг дараах алхмуудаар гүйцэтгэв. Үүнд:

- ✓ Байгаль орчны үнэлгээний өмнөх үе шатуудад тодорхойлсон төслийн байгаль орчин, нийгмийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн цар хүрээ, эрчим, хугацаа, шинж чанарыг нарийвчлан тодорхойлж, тоон ба чанарын шинжилгээ хийх.
- ✓ Болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний мэдээлэлд буулган судалж, сөрөг нөлөөллийн тархалт, үр дагаврыг үнэлэх.
- ✓ Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд төсөл хэрэгжих болон төслийн нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол, доройтлын түвшин тогтоох нэмэлт судалгаа, ажиглалт, хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх зэрэг орно.

Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны өөрчлөлт, нийгэм- эдийн засаг, бусад гэсэн 5 үндсэн бүлэгт багцлан хувааж, магадлан жагсаах аргаар судлав. Нөлөөллийг сөрөг (-), эерэг (+), нөлөөлөлгүй (0) гэсэн 3 бүлэглэлээр үнэлж, эрчимжилтийг: “бага”, “дунд”, “хүчтэй” гэсэн 3 зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлсэн болно.

Хүснэгт 14. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа			Нөлөө		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино	Дунд	Урт	Буцах	Буцалтгүй	Бага	Дунд	Хүчтэй
1. Байгалийн экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх усны урсац, горим, чанар өөрчлөгдөх	-					-		-			-
Уурхайн ухаш, хөрсний овоолго, зам болон үйлдвэрийн барилга бусад барилга байгууламжаас ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах	-					-		-			-
Уурхай болон үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах, шимт байдал алдагдах	-					-		-			-
Уурхайн олборлолтын улмаас геологийн тогтоц өөрчлөгдөх	-					-		-			-
Хүнд машин механизм, техник, тоног төхөөрөмж, хүний үйл ажиллагаатай холбоотойгоор ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх, хумигдах, үргэж дайчих	-					-		-			-
Бичил уур амьсгалын өөрчлөлт		-				-				-	
2. Байгалийн нөөц ашглалт											
Газрын нөөц баялаг	-					-		-			-
Гүний усны нөөц	-					-		-			-
Бэлчээрийн нөөц	-					-		-			-
Эрдэс түүхий эдийн нөөц	-					-		-			-
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
Шатах тослох материал, химийн бодисоор газар доор ус бохирдох		-				-		-			-
Тоосжилт, автомашины яндангаас гарах утаа, үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, хатаах зуухны яндангаас гарах утаа зэргээс агаар орчин бохирдох	-					-		-			-
ШТМ-ын хэрэглээ, хог хаягдал хадгалалт, зайлуулалттай хобоотойгоор хөрс бохирдох	-					-		-			-
Уурхайн олборлолтын процесс, үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас ургамлан бүрхэвч бохирдох	-					-		-			-
4. Байгалийн өнгө, төрх, түүх соёлын дурсгалт зүйл											
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-					-		-			-
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	-					-		-			-
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	0			0		0		0			0
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	0			0		0		0			0
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	0			0		0		0			0
5. Эдийн засаг, нийгмийн асуудал											
Улсад төлөх татвар, орлого нэмэгдэх	+				+			+		+	
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+			+		+	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+				+			+		+	
Ажлын байр нэмэгдэх	+				+			+		+	
Төслийн хэрэгцээг дагаад орон нутгийн үйлчилгээний байгууллагын эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+				+			+		+	
Хүний эрүүл мэндэд нөлөөлөх	-	-			-			-		-	
Нийт	20	3	0	5	9	8	7	15	2	8	12

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх шууд нөлөөлөл 20, шууд бус нөлөөлөл 3 байна. Нийт нөлөөллийн 2 нь бага эрчимтэй, 8 нь дунд эрчимтэй, 12 нь хүчтэй нөлөөлөлд хамрагдаж байна. Нийт нөлөөллийн 77.5% нь сөрөг, 22.5% нь эерэг байна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нийт нөлөөлөл нь шууд, урт хугацааны, хүчтэй нөлөөлөл байна.

Төслийн үйл ажиллагааны үед уурхайн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн магадлан жагсаалтад түүний нөлөөллийн үр дагаврыг “бага”, “дунд”, “их” гэсэн утгуудын аль тохирохыг “+” гэж тэмдэглэв.

Хүснэгт 15. Төслийн байршилтай холбоотой болзошгүй нөлөөлөл

№	Технологийн шийдлүүд	Нөлөөлөл		
		Бага	Дунд	Их
Уурхайн процесс				
1	Шимт хөрс хуулалт			+
2	Өрөмдлөг тэсэлгээ			+
3	Ухаж ачих			+
4	Дотоод тээвэр		+	
5	Овоолго үүсгэх		+	
6	Гадаад тээвэр		+	
Үйлдвэрийн процесс				
7	Нүүрс бэлдэх хэсэг		+	
8	Бутлах, шигших хэсэг	+		
9	Хатааж пресслэх хэсэг	+		
10	Савалгааны хэсэг	+		
11	Үйлдвэрийн хатаах зуух		+	

Төсөл хэрэгжих тухайн нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг мэдрэмтгий, салхи ихтэй, ургамлан нөмрөг бага, сул шороон хөрстэй тус тоосжилт үүсэх нөхцөлтэй. Орон нутгийн хэтийн хөгжилд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахгүй тул төсөл хэрэгжих орчинд байрлах Алтанширээ сумын иргэд болон бусад аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаатай зөрчилдөхгүй болно.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт “Өгөөмөр алт” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Хүрэн нүүрсний ордыг ил аргаар олборлон брикетлэх” төслийн үнэлгээний ажлын явцад үйл ажиллагааны товч танилцуулга, эрхлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн суурь төлөв байдлыг тодруулж үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийн цар хүрээг тооцон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний зөвлөмжийн хүрээнд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсрууллаа.

Төслийн хэрэгжилтийн явцад барилга байгууламжийн бүтээн байгуулалт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас хамгийн ихээр эвдрэлд орж сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн нь хөрсөн бүрхэвч юм. Сөрөг нөлөөллийн цар хүрээ багаас дунд зэрэг ба урьдчилан сэргийлэх болон бүтээн байгуулалтын дараа болон олборлолт дууссан хэсэгт нөхөн сэргээх талаар төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх тохиолдолд нөлөөллийн эрчим эрс буурах боломжтой.

Төслийн ерөнхий үнэлгээний нөхцөлд заагдсаны дагуу байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар жил бүрийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү тайлангийн 5 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) үндэслэн боловсруулж БОАЖЯ-д ирүүлэн батлуулах ба батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох газруудад хүргүүлж байх шаардлагатай. Үүнээс гадна тус Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ), түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь”-ийн дагуу оролцогч сонирхогч талуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.

4.1. Байгаль орчны менежментийн арга хэмжээ ба үүрэг

Байгаль хамгаалах зардлыг урьдчилсан байдлаар гаргасан бөгөөд төслийн үйл ажиллагаанд орсон технологийн өөрчлөлт, ажлын ачаалал, илүү нарийвчилсан мэдээ сэлт, байгаль хамгаалах ажлын үр дүнтэй холбогдож өөрчлөгдөж байх болно. Байгаль хамгаалахад хийж гүйцэтгэх ажлын жагсаалтад цаг хугацаа гэхгүйгээр хамгийн түрүүнд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ болон сөрөг нөлөөллийг бууруулах талаар жил бүр тогтмол хэрэгжүүлж байх байгаль орчны менежмент ба хяналт шинжилгээний арга хэмжээнүүдийн жилийн дундаж зардлыг тусгасан болно.

Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулж нөхөн сэргээх ажил нь тухайн байгууллага хамт олны энэ чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг оновчтой нарийн шийдвэрлэх ажлаас эхэлнэ. Мөн энэ талаар гүйцэтгэх ажилд зориулсан хүрэлцэхүйц хэмжээний зардал тухайн жилийн санхүүгийн төсөвт бүрэн тусгагдаж батлагдсан байх шаардлагатай.

Баримт бичигт тусгасан арга хэмжээг компанийн зүгээс цаг тухай бүр нь бүрэн хэрэгжүүлж байх шаардлагатай бөгөөд холбогдох яам, аймаг, сум орон нутгийн

Мэргэжлийн хяналтын байгууллага, байгаль орчны хяналтын улсын байцаагчид шалгаж, биелэлтэнд хяналт тавьж байх юм. Менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэхдээ төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлангийн холбогдох бүлгүүд, хавсралтанд өгөгдсөн мэдээллийг сайн судалсан байвал зохино.

Байгууллагын байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны талаарх жилийн тайланд тухайн жилд байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулж нөхөн сэргээх талаар авч хэрэгжүүлсэн бүх арга хэмжээнүүдийг менежментийн төлөвлөгөөнд тусгаснаар хийсэн эсэхийг оруулсан байх ёстой. Тайланд тухайн жил ямар бодлого, зорилт тавьсан, түүнд хүрэхийн тулд техник эдийн засаг санхүүгийн хувьд жилийн төсөв төлөвлөгөөнд хэрхэн тусгагдаж санхүүжигдсэн, ямар биелэлт хичнээн хувьд хүрсэн, дараа жил ямар ажил хийх хэрэгтэй талаар тодохой тусгасан байх хэрэгтэй.

4.2. Байгаль орчны дотоод хяналт шалгалт

“Хүрэн нүүрсний ордыг ил аргаар олборлон брикетлэх” төсөл нь жил ирэх тутам үйл ажиллагааны хүрээ өргөжиж, түүнд хамаарах байгаль орчны асуудал улам өргөн цар хүрээтэй болж байна. Иймээс байгаль хамгаалах ажлыг хариуцсан, байгаль орчны мэргэжилтэнтэй байх шаардлагатай байна. Энэ мэргэжилтний зүгээс одоо байгаль орчинд бий болоод байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, байгаль хамгааллын ажлыг зохистой жигд явуулах, байгаль хамгааллын дотоодын хяналтыг сайжруулахад үр дүнгээ өгөх юм.

Байгаль орчны мэргэжилтний үүрэг

- ✓ Байгаль орчны мэргэжилтэн нь уурхайн ашиглалт, технологи ажиллагаанд байгаль орчны хувьд анхаарал тавьж үйл ажиллагааны талаар өдөр бүрийн ажлын тэмдэглэл хөтөлж үйлдвэрийн цех, хэсгийн дарга нэг бүрд өдөр бүр болон долоо хоног бүр танилцуулах.
- ✓ Байгаль орчны мэргэжилтэн нь үйл нийцэх тохиолдолд, төлөвлөөгүй үйл явдлын хариу арга хэмжээ болон байгаль орчны асуудалтай хамааралтай ажил зогсоох явдал зэргийг бэлтгэгдсэн маягтан дээр тэмдэглэнэ.
- ✓ Байгаль орчны мэргэжилтэн нь ус болон агаарын чанар, дуу чимээ шуугианы түвшинг хянах ажиглалтын хөтөлбөртэй холбогдуулан хэрэгцээтэй мэдээллийн бүртгэл хөтөлбөл зохино.
- ✓ Байгаль орчны мэргэжилтэн нь гуравдахь талын ажиглагч болон зохицуулагч байгууллагын төлөөлөгч нартай харилцах бичиг баримтыг бүрдүүлнэ.
- ✓ Байгаль орчны мэргэжилтэн нь уурхайн ажлын талбай, үйлдвэрийн цех хэсгүүдэд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар бүхий л үзүүлэлт болон загварыг тэдгээрийн удирдлагуудад танилцуулж шаардлагатай үед төсөлд заасан стандарт болон зорилготой нийцүүлэх зорилгоор альтернатив үзүүлэлт болон загварыг гаргаж болно.
- ✓ Байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны асуудалтай холбоотой буюу аливаа нөлөөлөл бүхий үзүүлэлт болон дизайны өөрчлөлтийн баримт бичгийг үйлдэж эдгээр өөрчлөлтийн улмаас гарах үр дүн, хор уршгийг гаргаж тусална.
- ✓ Байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны төлөвлөлт, дизайн, үзүүлэлт болон холбогдох зөвшөөрөлтэй холбогдсон бүхий л асуудлын талаарх фото зураг бүхий баримтжуулсан тэмдэглэл хөтөлнө.
- ✓ Байгаль орчны мэргэжилтэн нь жил бүр ОХШХ-ийн хэрэгжилтийг хангах, үүнтэй холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд биечлэн оролцоно.

- ✓ Байгаль орчны мэргэжилтэн нь үйлдвэрийн орчим болон далд уурхайд бий болоод байгаа сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг холбогдох цех, хэсгүүдээр бүрэн арилгуулах талаар үйлдвэрийн удирдлагуудтай хамтарч үр бүтээлтэй ажиллах шаардлагатай.

4.3. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах

Энэхүү менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ тайлангийн холбогдох бүлгүүдийг сайн судалсан байвал зохино. Энэ төлөвлөгөөнд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, нөхөн сэргээлт, газар шорооны ажилтай холбоотой Монгол улсын стандартууд, ус, агаарын чанарын стандартууд, байгаль орчны хууль тогтоомжийг зөрчигдсөд хүлээлгэх торгууль, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай норм, зарим хүснэгт, жагсаалт, схем, зургийг хавсаргасан нь төлөвлөгөөний хэрэгжилт, хяналтын ажлын аль алинд нь чухал ач холбогдолтойн гадна хэрэглэхэд хялбар дөхөм болж байгаа юм.

4.4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

Хүснэгт 16. Барилга угсралтын үеийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Барилгын ажлын үеийн агаарын бохирдол	Барилгын ажлыг богино хугацаанд гүйцэтгэх	60 хоног	-	-	Барилгын ажлын хугацаанд	-
	Техникийн шаардлага, зураг төслийн төлөвлөлтөөс бусад газар шимт хөрсийг талхлахаас сэргийлэх	Төслийн 52.3 га барилга байгууламжид өртөх талбай	-	-		-
	Барилгын ажлын үед зам талбайг чийгшүүлж тоосжилт тархахаас сэргийлэх	Барилгын ажил гүйцэтгэх талбайн ойр орчим	1га- 2м ³	1850.0	Хоногийн хамгийн хуурайшилтай хугацаанд	-
	Уурхайн барилга байгууламжийг уурхайн төвлөрсөн цахилгааны шугам сүлжээнд холбох	14 хоног	-	-	Барилгын ажлын хугацаанд	Барилгын төсөв зохиох дүрэм
Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвчийн доройтол	Барилга байгууламжийн төлөвлөлтийг хийхдээ төлөвлөгөөт зураг төслийн дагуу гүйцэтгэх	60 хоног	-	-	Барилгын ажлын хугацаанд	Барилгын төсөв зохиох дүрэм
	Байгууламжийн хэсэгт шинээр өртөх газрын шимт хөрсний үеийг зайлшгүй урьдчилан хуулж хадгалах эсхүл ногоон байгууламжид эргүүлэн ашиглах	1400 м ³ шимт хөрс	2000.0	Үйл ажиллагааны зардал	Барилгын ажлын өмнө	Барилгын төсөв зохиох дүрэм
	Нийтийн үйлчилгээний зам талбайг байгалийн материалаар засч тохижуулах	Авто, зогсоол, зам талбайн хэмжээнд	Барилгын ажлын зардалд хамаарна		Барилгын ажлын хугацаанд	-
	Тээврийн хэрэгслийн зорчих хэсгийг бетондож хатуу хучилттай болгохоор төлөвлөсөн ажлыг хугацаанд нь хэрэгжүүлэх	Уурхай, үйлдвэрийн зам				
Усны нөөц ашиглалт, усны бохирдол үүсэх	Барилгын ажилд шаардлагатай цэвэр усыг зөвшөөрөлтэй худаг, уст цэгүүдээс авч ашиглах, зөвшөөрөлгүй худаг гаргаж ус ашиглахыг хориглох	Зохион байгуулах	-	-		Усны тухай хууль
	Зүлэг ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар хур тунадас ихтэй жил гадаргын усыг (үерийн урсац) түлхүү ашиглах талаар төлөвлөлтийг хийх Гадаргын усыг ашиглаж усалгаа хийх тохиолдолд усны барилга байгууламжийн (үерийн усыг боох далан) зураг төслийг мэргэжлийн байгууллагаар боловсруулан усны дүгнэлтийг холбогдох мэргэжлийн байгууллагаар гаргуулж ашиглах	Ажлын гүйцэтгэлээр	Гүйцэтгэлийн зардалд хамаарна		Төлөвлөлтийн хугацаанд	Хөв цөөрөм байгуулж ашиглах арга технологи

Ургамлан нөмрөгийн устгал, талхагдал	Уурхайн барилга байгууламж барих барилгын суурийн хэсэгт өртөх ашигт ургамал бүхий бүлгэмдлийн үрээр нөхөн сэргээх боломжгүй төрөл зүйлүүдийг барилгын ажлыг гүйцэтгэхээс өмнө шилжүүлэн суулгах	Уурхайн бүсийн 1 га газрын хэмжээнд	1га-200.0төг	200.0	Барилгын ажлын өмнөх хугацаанд	-
Амьтдын дайжилт, амьдрах орчны хязгаарлалт, доройтол	Барилгын дуу чимээ ихтэй техник, түр объектуудыг эдэлбэрийн хотжилт түлхүү хэсэгт байршуулж ашиглах, барилгын ажлаар хөхтөн, шувуу зэрэг амьтдын үүрийг бусниулж сүйтгэхгүй байх, зайлшгүй шаардлагатай тохиолдолд үүрийг шилжүүлэх, өөр байршилд сэргээх	Зохион байгуулах 10 хоног	500.0	500.0	Барилгын ажлын өмнөх болон үргэлжлэх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага: MNS 5002 - 2000
	Барилгын ажлыг шөнийн цагт гүйцэтгэхийг хориглох		-	-		-
Ажилчдын эрүүл мэнд доройтох	Барилгын ажилчдын ажилд Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаархи бүх хууль тогтоомжийг, хөдөлмөр хамгааллын багц стандартуудыг мөрдүүлж ажиллах		300.0	300.0	Барилгын ажил үргэлжлэх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 оны 05 сарын 22 өдөр
	Барилгын ажилчдын хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалсан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулах		ҮА-ны зардал			
	Ажилчдыг ХХАА-ны хэрэгслээр хангах, ХХАА-ны хэрэгслээр хангахдаа MNS 5620:2006 стандартыг баримтлах	500.0	500.0			
Ажилчдад ХХАА-ны талаар сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны самбарыг ажлын талбарт байршуулах	250.0	250.0				
Нийт дүн			3600.0			

Хүснэгт 17. Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
1	АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ				
	Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд:	Нүүрс ачилтын талбай, хөрс чулуулгийн овоолго, тэвэрлэлтийн зам зэрэг хөдөлгөөн ихтэй газруудад салхи ихтэй дулаан үед агаарт болон зам дагуу ус шүрших замаар тоосролтыг бууруулах арга хэмжээ авах, цаашид зам талбайн гадаргад хлорт кальцийн уусмал цацаж тодорхой үе үүсгэх, хайрга, битуман хучилт хийх эсвэл полимер материалан дэвсгэр дэвсэж үйл ажиллагаа явуулах.	Уурхайн эвдрэлд орсон талбайн сул шороотой хэсэгт	2000.0	БОС-ын 1995 оны 153тоот тушаал

№	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
	Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох Тэсэлгээний ажлын үед үүсэх тоосжилт	Тоос шороо их босгодог ажилд байгалийн болон зориудаар хийсэн салхины чиглэл өөрчлөх, хурд сааруулах байгууламж, хаалтуудыг ашиглах.	Үйл ажиллагааны турш	ҮА зардал	-
		Овоолгыг салхи ихтэй үед услах арга хэмжээ авах, тэдгээрийн гадаргууг ургамалжуулах	Уурхайн овоолгод, хуурайшилт ихтэй салхитай үед	1500.0	MNS 5912:2023
		Нүүрс тээвэрлэх машинуудыг тэвшний бүтээлгээр хангаж, ашиглалтанд нь хяналт тавих, хурдыг хязгаарлах.	Үйл ажиллагааны турш	1600.0	-
		Ажлын байрны температур, чийглэг, гэрэлтүүлэг, шуугиан, агаарын чанар найрлага, цацрагийн хэмжээ зэргийг тодорхойлж дүгнэлт өгч сөрөг нөлөөллийг бууруулах технологийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Үйл ажиллагааны турш	400.0	MNS 5387:2004
		Нүүрс олборлох, тээвэрлэх, брикетлэх, ачих шугамын тоосжилтыг хянаж, тоос бууруулах технологийн арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш	-	-
		Нүүрсийг нам өндөр лүү буулгахдаа битүү суваг хоолой ашиглах, суваг хоолойн бүтэн байдалд хяналт тавих	Үйл ажиллагааны турш	-	-
		Уурхайн дулааны станцын техник тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх.	Үйл ажиллагааны турш	-	-
		Нүүрсний ил агуулахыг эмх замбараатай болгож, шинэчлэн сайжруулах, нүүрс ил задгай асгахыг зогсоох арга хэмжээ авах, цаашид битүү агуулахад хадгалах.	Үйл ажиллагааны турш	-	-
		Тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд болон Олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж, түүнд нийцүүлж ажиллах.	Үйл ажиллагааны турш	-	MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид
		Шатахуун түлшний агуулах, станцын түгээгүүрийг хий уур буцаагчаар тоноглох	Үйл ажиллагааны турш	-	-
Гоожсон шатахуун түлшийг цэвэрлэх материалын нөөцтэй байх	Үйл ажиллагааны турш	-	-		
Нийт дүн				5500.0	
2	ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ				
	Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос	Шимт хөрсний овоолго хийх хадгалах	Үйл ажиллагааны турш	-	ТЭЗҮ-ийн төлөвлөгөөний дагуу
		Уурхайн орчны замыг стандартын дагуу тавих, тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлэх	Үйл ажиллагааны турш	750.0	-

№	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
	<p>бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх.</p> <p>Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах</p>	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтанд хяналт тавих	Үйл ажиллагааны турш	-	
		Машин механизмын засвар үйлчилгээ хийх талбай, ШТМ-ын агуулах, хаягдал тос хадгалах цэг, ШТС зэргийн талбайг бетон хучилт хийх	Үйл ажиллагаа эхлэх үед	Барилгын ажлын зардал	Хог хаягдлын тухай хууль
		Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	-	-
		Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хураах	Үйл ажиллагааны турш	ҮА-ны зардалд	ТЭЗҮ-ийн төлөвлөгөөний дагуу
		Уурхайн хүрээнд хийгдэх зам өргөсгөх, шинээр үер усны хамгаалалт, далан байгуулах, суваг шуудуу татах бусад нүх цооног ухах зэрэг газар шорооны их бага ажлын үед үржил шимт хөрсийг нимгэн зузаанаас хамааруулан 15-20 см-ийн зузаантай хуулж, нөхөн сэргээлтэнд буцаан ашиглах зориулалтаар түр овоолж хадгална.	Үйл ажиллагааны турш	-	Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм
		Ажлын талбай ба туслах зам дагуу үүссэн хотос хонхор зэрэг хөрсний элэгдэл, эвдрэлийг их бага гэхгүйгээр тухай бүр нь дүүргэх, тэгшлэх арга хэмжээ авах, талбайн эмх цэгцтэй байдлыг хангаж ажиллах	Үйл ажиллагааны турш	-	-
		Автомашин хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш	-	Уурхайн дотоод журам
		Автомашин тос масло асгарч бохирдсон хөрсийг хуулан авч тусгаарлагч гадаргуу дээр овоолон 18-20%-ийн хлораминий уусмалаар бороожуулан ариутгаж, нефтийн бүтээгдэхүүний агуулга 0.07мг/кг-аас ихгүй, 4 этилт хар тугалганы хэмжээ 0.05 мг/кг-аас ихгүй нөхцөлд буцаан байршуулах	Үйл ажиллагааны турш	800.0	-
		Ахуйн гаралтай шингэн хаягдлыг зориулалтын талбайд түр хадгалж биобэлдмэлээр тогтмол ариутгах, цаашид байгаль орчинд халгүй зайлуулах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны турш	700.0	MNS 4943: 2015
Нийт дүн				2250.0	
3	УСНЫ НӨӨЦ, ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ				
	Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг	Ахуйн бохир ус зайлуулах цооног байгуулах ашиглах	Барилгын ажил эхлэх үед	4500.0	MNS 4943: 2015
		Усалгаа болон ахуйн усны хэрэглээг тооцох Хэмнэлттэй зарцуулах техник технологи ашиглах	Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамаарах ба 1 м3 гадаргын усны ЭЭЗ үнэлгээ 3700 төг байна. Ахуйн зориулалтаар ашиглавал 0.25 коэффициентээр/ үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэх усны үнэлгээ нь 925 төг/м3 болох юм.		

№	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
	алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх	Үйл ажилллагааны турш	Гэрээний дагуу	Усны тухай хууль
		Бохир усны хоолойг сайн чанарын хоолойг сонгож ашиглах, хяналт тавих	Үйл ажилллагааны турш	ҮА зардал	-
		Үерийн ус зайлуулах суваг хоолойн оруулга, гаргалгыг бэхэлгээтэй хийж, хөрс угаагдах эвдрэхээс хамгаалах	Үйл ажилллагааны турш	ҮА зардал	-
		Шүүрлийн усыг технологит ашиглахаас өмнө лабораторид өгч шинжлүүлж байх	Үйл ажилллагааны турш	172.0	Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт MNS 6148:2010
Нийт дүн				4672.0	
4	ДУУ ЧИМЭЭ				
	Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах	Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх	Үйл ажилллагааны турш	-	MNS 5002: 2000
		Дуу шуугианы хэмжилт (2 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий машин механизмийн ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах	Улиралд 1 удаа дууны түвшин хэмжигч NL-04 багажаар хэмжилтийг хийнэ.	600.0	
		Дуу шуугианы эх үүсвэрийг тусгаарлах эсвэл шингээх зориулалтын байгууламжтай байх, дуу чимээ ихтэй цех хэсгүүдийн ханыг ойлт бага шингээх чадвар сайн материалаар хийх	-	ҮА зардал	
Нийт дүн				600.0	
5	УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ				
